

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2020.06.18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

“Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилт, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ хийж, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д үндэслэн гүйцэтгэв.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.4 дахь заалтын дагуу гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

“Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн Нэг. Төрийн удирдлагын бодлогын хүрээнд 12 арга хэмжээ,

Хоёр. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд 4 арга хэмжээ,


Гурав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бодлогын хүрээнд 18 арга хэмжээ,

Дөрөв. Нийгмийн бодлогын хүрээнд 26 арга хэмжээ, нийт 4 бодлогын хүрээнд **60** арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2017-2020 оны зорилт, арга хэмжээний тоог харьцуулж хүснэгт, графикаар харуулбал:

Он	Зорилтын тоо	Арга хэмжээ
2017 он	2	39
2018 он	2	46
2019 он	4	56
2020 он	4	60
Дундаж	3	50.2

Зорилт, арга хэмжээ, тоо



2017-2020 онуудад хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хувьд жилд дунджаар 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Арга хэмжээний тоо 4-7 арга хэмжээгээр өсөлттэй байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Гурав. Дүгнэлт

“Дархан-Уул аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хяналтанд авсан 4 бодлогын **60 арга хэмжээний** ерөнхий үнэлгээ **70.55%** буюу **3.52 оноо** буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** үнэлэгдлээ.

- “Үр дүнтэй” буюу 100% үнэлгээтэй 15 арга хэмжээ,
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70% үнэлгээтэй 25 арга хэмжээ,
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40% үнэлгээтэй 14 арга хэмжээ,
- “Үр дүнгүй” буюу 0% үнэлгээтэй 0 арга хэмжээ
- “Үнэлэх боломжгүй” -6 арга хэмжээ байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Арга хэмжээ, үүнээс				
			Зорилт-1	Зорилт-2	Зорилт-3	Зорилт-4	
1.	Хяналтанд авсан бодлогын тоо	4	Төрийн удирдлагын бодлого	Хууль, эрх зүйн бодлого	Хөгжлийн бодлого, төлөвлөлт	Нийгмийн бодлого	
2.	Хяналтад авсан арга хэмжээний тоо	60	12	4	18	26	
3	Хэрэгжилт, үүнээс	“Үр дүнтэй” -100.0%	15	4	3	2	6
		“Тодорхой үр дүнд хүрсэн”-70.0%	25	2	1	7	15
		“Эрчимжүүлэх шаардлагатай”-40.0%	14	2	-	9	3
		“Үр дүнгүй”-0%	-	-	-	-	-
		“Үнэлэх боломжгүй”	6	4	-	-	2
Хэрэгжилтийн хувь, оноо		70.55% буюу 3.52 оноо	77.50% буюу 3.87 оноо	92.5% буюу 4.62 оноо	58.33% буюу 2.91 оноо	73.75% буюу 3.68 оноо	

Үндсэн чиглэлд тусгагдсан 60 арга хэмжээнээс 66.66% буюу 40 арга хэмжээний хэрэгжилтийг **Хангалттай** гэж үзэж байна.

“Үнэлэх боломжгүй” 6 арга хэмжээг дэлгэрэнгүй танилцуулбал:

Нэг. “Төрийн удирдлага”-ын бодлого 4 арга хэмжээ

9.	ЗГҮАХ-ийн 5.6.9.1 дэх заалт, ЗДҮАХ-ийн 1.11.1.12 дахь зорилтын хүрээнд	Төрийн албан хаагчдыг гадаад улсад мэргэжлийн чиглэлээр дадлага, сургалтад хамруулна	Гадаад харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудад төрийн албан хаагчид дадлага, сургалтад хамрагдсан байна	Аймгийн хэмжээнд нийт 20 албан хаагч гадаад улсад мэргэжлийн чиглэлээр дадлага, сургалтад хамрагдаж чадавжсан байна	Цаг үеийн нөхцөл байдлаас /Ковид-19/ шалтгаалж гадаад улсад мэргэжлийн чиглэлээр дадлага, сургалтад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг сургах боломжгүй болсон.	Үнэлэх боломжгүй
10.	ЗДҮАХ-ийн 1.5 дахь зорилтын хүрээнд	Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015/MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг байнга сайжруулна	Иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлнэ	Сэтгэл ханамжийн түвшинг 2 хүртэл хувиар нэмэгдсэн байна	Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
11.	МУЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоол, ЗДҮАХ-ийн 1.9 дэх зорилтын хүрээнд	Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйг сайжруулна	Аймгийн ерөнхий үнэлгээг дээшлүүлнэ	Аймгийн ерөнхий үнэлгээ 86,8 хувь буюу 4,34 оноонд хүрсэн байна.	Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
12.	МУЗГ-ын 2018 оны 67 дүгээр тогтоол, ЗДҮАХ-ийн 8.3 дахь зорилтын хүрээнд	Гамшгийн эрсдэл буурах, иргэдийн аюулгүй ажлын байр эрүүл ахуйн нөхцөл сайжирна.	Иргэдийн аюулгүй амьдрах баталгаа дээшилнэ.	Аймгийн гамшгийн эрсдэлийн суурь үнэлгээ хийгдэн.	2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны Дугаар 15/07 тогтоолоор Аймгийн хэмжээнд Гамшгийн эрсдэлийн судалгаа хийх ажилд 50.0 сая төгрөг батлагдсан. Дэлхий нийтийг хамарсан "Цар тахал"-аас шалтгаалж улс орон, аж ахуйн нэгж байгууллаг, иргэдийн санхүү, эдийн засагт нөлөөлсөн. Иймд гамшигийн эрсдэлийн судалгаа хийх ажлыг түр хойшлуулсан. Аймгийн онцгой комисс болон МХГ өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу Анагаахын 4-н замын уулзвараас үйлдвэрийн бүсийн 3-н замын уулзвар хүртэлх 1.9 км авто замын засвар шинэчлэлтийн ажилд хөрөнгийг шилжүүлсэн.	Үнэлэх боломжгүй

Эдгээр арга хэмжээний хувьд 10,11 дүгээр арга хэмжээний хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу 2020 оны 4 улиралд зохион байгуулахаар төлөвлөгдсөн. 2020 оны жилийн эцэст бүрэн хэрэгжих боломжтой арга хэмжээнүүд байна.

Харин 9,12 дугаар арга хэмжээнүүдийн хувьд цаг үеийн нөхцөл байдал (Ковид 19)-аас шалтгаалсан байна. Цаашид хэрэгжих эсэх нь гадны хүчин зүйлээс шалтгаалж байна.

Дөрөв. "Нийгмийн бодлого"-ын 2 арга хэмжээ

44	МУЗГ-ын 2019 оны 159 дүгээр баталсан "Ажилгүйдэл ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн 5.1.7, ЗДҮАХ-ийн 6.3.11.3, 6.3.2 дахь заалтын хүрээнд	ЕБС-ийн 9,12-р ангийн төгсөгчдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, аймгийн Их дээд сургууль, коллеж төгсөгчдийг ажлын байраар хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгож, ажилгүйдлийг тодорхой түвшинд бууруулна	ЕБС-ийн 9-12-р ангийн 1000 сурагч, ААНБ-аас 100 хүн, Их дээд сургууль, коллеж төгсөгчдөөс 200 хүнийг тус тус дадлагажуулах сургалтад хамруулсан байна	БСУГ-аас ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 12 дугаар ангийн 16 сургуулийн 926 сурагч, 12-р ангид хичээл ордог 120 багш, 75 эцэг эхтэй уулзалт хийж элсэлтийн ерөнхий шалгалт, улсын шалгалтад бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Мөн хөл хорио тогтоосон хугацаанд 12 дугаар ангийн 1156 сурагч 2000 эцэг эх, анги удирдсан 44 багш 6 мэргэжилтнүүдээс бүрдсэн "Цахим зөвлөх" нэртэй 40 цахим фасебүүк групп үүсгэн Боловсролын Үнэлгээний төвөөс зохион байгуулж буй зөвлөмж, ЭЭШ-ын теле хичээлээс гадна мэргэжил сонголтын чиглэлээр 20 зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. ШУТИС-ийн Дархан дахь технологийн сургуулийн 11 багш нар аймгийн ЕБ-ын 16 сургуулийн 823 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжлээ хэрхэн сонгох талаарх сургалтыг ЭЭШ-ийн давтлагын үеэр танхимаар зохион байгуулсан. ХХҮГ-аас Оюуны Ирээдүй цогцолбор сургуулийн 9-12-р ангийн 400 сурагчдыг "Миний мэргэжил миний сонголт", "21-р зууны ур чадвар" сэдэвт 3 модулын цахим сургалтад хамруулсан. ХЭДС-аас 2,4 сая төгрөг зарцуулсан. COVID-19 цар тахлын улмаас дадлагажуулах сургалт хойшилсон.	Үнэлэх боломжгүй
----	--	---	---	---	--	------------------

54	ЗДҮАХ-ийн 6.3.11.4 дахь заалт, Залуучуудын эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн 6.1 дэх заалтын хүрээнд	"Start Up" арга хэмжээг зохион байгуулах замаар шинэ санаа, шилдэг технологийг дэмжинэ	15-34 насны хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эхлэх хүсэлтэй залуучуудыг эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт хамруулна	10 төслийг шалгаруулж санхүүгийн дэмжлэг олгон ажлын байр бий болгосон байна.	Хугацаа болоогүй.	Үнэлэх боломжгүй
----	--	--	--	---	-------------------	------------------

Дээрх 2 арга хэмжээний хувьд 44 дүгээр арга хэмжээний хэрэгжилт мөн цаг үеийн нөхцөл байдал (Ковид 19)-аас шалтгаалсан байна. Цаашид хэрэгжих эсэх нь гадны хүчин зүйлээс шалтгаалж байна.

54 дүгээр арга хэмжээний хувьд хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу 2020 оны 3 улиралд зохион байгуулахаар төлөвлөгдсөн. 2020 оны жилийн эцэст бүрэн хэрэгжих боломжтой арга хэмжээнүүд байна.

Дөрөв.Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ (Зөвлөмж):

Ололттой тал

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2019.1.28-ны өдөр танилцаж баталсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан,
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020.01.28-ны өдөр баталсан “ 2020 онд аймгийн ЗДТГ-т ирүүлэх болон дээд шатны байгууллагат хүргүүлэх хугацаатай мэдээ, тайлангийн хуваарь”-ийн дагуу хугацаанд нь буюу 2020.06.18-ны өдөр тайланг ХШҮДАХ-т ирүүлсэн.

Анхаарах асуудал:

1. Эрчимжүүлэх шаардлагатай 14 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахад удирдлага, зохион байгуулалтыг авч хэрэгжүүлэх, Гурав. Хөгжлийн бодлого, төлөвлөлт”-ийн бодлогод тусгагдсан 9 арга хэмжээнүүдийн хувьд гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын хугацаанд хяналтыг тавьж ажиллавал хэрэгжих бүрэн боломжтойг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА С.НАСАНБАТ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН

